



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 153

Улаанбаатар хот

Үнэт цаас бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 07-р сарын 07-ны өдрийн 269 тоот тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8.10.11-р заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Бүртгэлийн журам”-ын 20.3-р заалт, “Баянхайрхан” хувьцаат компанийн 2014 оны 07-р сарын 09-ний өдрийн 25/14 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу хийсэн бүртгэлийн шалгалтын тайлан, 2014 оны 10-р сарын 03-ны өдрийн захирлын зөвлөлийн хурлын санал, дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. “Баянхайрхан” хувьцаат компанийн гаргасан 215,706 ширхэг хувьцааг тус компанид нэгдэж буй “Бинсэ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хөрөнгөд ноогдох 1,052,614 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн нийт 1,268,320 ширхэг хувьцаатай, компанийн оноосон нэрийг “Бинсэ” хувьцаат компани болгон “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн бүртгэлд өөрчлөлт оруулсугай.
2. Холбогдох мэдээллийн санд өөрчлөлт оруулж, “Үнэт цаасны төлбөр, тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” хязгаарлагдмал хариуцлагатай компанид хадгаламжид өөрчлөлт оруулах мэдэгдэл хүргүүлэхийг Үйл ажиллагааны газар /М.Энхтуяа/-т үүрэг болгосугай.
3. “Баянхайрхан” ХК-ийн бүртгэлд өөрчлөлт тухай мэдээллийг олон нийтэд хүргэхийг Зах зээлийн хөгжлийн газар /Ж.Мягмарсүрэн/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.АНГАР

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО,
ХАДГАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД
ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ**

Хэнд: “Үнэт цаасны төлбөр тооцоо,
төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д

№ 315

Огноо: 2014.10.24

ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭТ ЦААС БҮРТГЭГДСЭН БАЙДАЛ	ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ОРОХ ӨӨРЧЛӨЛТ
Мэдэгдлийн агуулга:	Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай	
Үндэслэл:	Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 07-р сарын 07-ны өдрийн 269 тоот тогтоол, МХБ-ийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 10-р сарын 03-ны өдрийн № 184 тоот тушаал	
Санхүүгийн хэрэгсэл: /хувьцаа, өрийн хэрэгсэл гэх мэт/	Хувьцаа	Хувьцаа
Үнэт цаасны нэр:	“Баянхайрхан” ХК	“Бинсэ” ХК
Үнэт цаасны код: /үсгэн, тоон/	BHR/315	BHR/315
Үнэт цаасны төрөл: /энгийн, давуу эрхийн/	Энгийн	Энгийн
Үнэт цаасны хэлбэр: /биет, биет бус/	Биет бус	Биет бус
Нийт үнэт цаасны тоо: /ширхэг/	215,706	1,268,320
Энгийн	тоо /ширхэг/	215,706
	хувь /%/	100%
Олон нийтийн Эзэмшил	тоо /ширхэг/	215,706
	хувь /%/	100%
Төрийн эзэмшил	тоо /ширхэг/	-
	хувь /%/	-
Үнэт цаасны нэрлэсэн үнэ: /төгрөг/	100	100
Үнэт цаасны нийт үнийн дүн: /төгрөг/	21,570,600	126,832,000
Бусад		“Баянхайрхан” ХК-д “Бинсэ” ХХК-г нэгтгэж, 1,052,614 ширхэг хувьцааг нэмж бүртгэсэн

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.АНГАР